

М.Золзаяа

ХИДС-д тэнхимийн эрхлэгч,  
докторант

МЭРГЭЖЛИЙН ЁС ЗҮЙ ХИЙГЭЭД  
“МОНГОЛЫН НУУЦ ТОВЧОО”

Мэргэжил гэдэг нь тусгай бэлтгэл, амьдралын туршлага, бие хүний тодорхой шинж чанарыг хүнээс шаардаг хөдөлмөрийн үйл ажиллагааны төрөл<sup>1</sup>. Ямар ч мэргэжил өөртөө зайлшгүй даван туулах, шийдэх, дахин давтагдашгүй нөхцөл, бэрхшээл зөрчлүүдтэй байдаг нь мэргэжлийн өвөрмөц ёс суртахууныг төрүүлнэ. Хүн төрөлхтөний нийтлэг ёс суртахууны хэм хэмжээ нь мэргэжилд зохицсон шинж байдлаар илрэхийг мэргэжлийн ёс зүй гэнэ<sup>2</sup>. Мэргэжлийн ёс зүй нь хавсарга ёс зүйн асуудалтай зарим талаар давхцдаг боловч яг адилхан биш гэж судлаачид үздэг байна. Хавсарга ёс зүй нь мэргэжлийн зан байдлыг хянаж үзэх, мэргэжил хоорондын ёс зүйн асуудал, мэргэжлийн бүлгүүдийн дүрэм журамд этик анализ хийх, дүрэм журам боловсруулахдаа тодорхой мэргэжилтэй болон мэргэжлийн бус бүлгүүдийн дунд хэлэлцүүлэг явуулах зэрэг үүрэгтэй. Мэргэжил бүрт тохирсон мэргэжлийн ёс зүй нь нийгмийн ёс суртахууны өвөрмөц шаардлагаар зохицуулагддаг бөгөөд мэргэжилтний ажлын үүрэг хариуцлага, үнэнч шударга байх, сайн ба муу тал, мэргэжлийн нэр хүндийг эрхэмлэх, никжин сэтгэл зэрэг үндсэн ойлголтуудтай.

Орчин үеийн нийгэмд мэргэжих үйл явцыг гүнзгийрүүлэх шаардлага тавигдаж байгаа бөгөөд мэргэжлийн ёс суртахууны агуулга, хэлбэрийг тодорхойлоход ёс суртахууны хэм хэмжээ, үнэлэмж, зан суртахуун-сэтгэлзүйн тохироо, хүмүүсийн хоорондын зан байдлыг зохицуулах дүрэм журам, хууль, үнэлэмжийн өөрчлөлт, мэргэжлийн үйл ажиллагаанд хандах зөвшөөрөл, хориг зэргийг харгалзан үзнэ<sup>3</sup>. Жишээ нь: Европын болон дэлхий нийтийн анагаах ухаанд Гиппократ\* эмчийн ёс зүйн мэдлэг уламжлагдаар ирсэн. Ялангуяа түүний боловсруулсан тангараг нь эмч мэргэжлийн ёс зүйн гол хууль болжээ. Гиппократ эмчийн дэвшүүлсэн ёс зүйн зарчим нь:

1. чин сэтгэлээс хүний амьдралыг хүндлэх 2. буяныг урьтал болгож, өвчтөнд өчүүхэн ч хор хүргэхгүй байх 3. өвчний тухай мэдээлэхдээ хянуур байх 4. зарим үед анагаахын харамгүй тусламж үзүүлэх 5. өөрийн мэргэжилдээ хүндэтгэлтэй байх зэрэг юм. Харин хуульчийн ёс зүй нь мэргэжлийнхээ үүргийг биелүүлэхтэй холбоотойгоор тавигддаг тусгай шаардлагуудаас бүтдэг байна<sup>4</sup>.

XIII зууны үеийн Монголд цөөнгүй ажил мэргэжлийн төрөл байсан нь “Монголын нууц товчоо” болон түүхийн бусад эх сурвалжуудад тусгагдсан байдаг. Тухайлбал Тэмүжин 1189 онд Хамаг Монголын ханд өргөмжлөгдөөд

<sup>1</sup> Краткий толковый словарь эзукологических понятий УБ., 1994 86-р тал

<sup>2</sup> В.Өлзийбаяр Ажил мэргэжлийн ёс зүйг харгалзан удирдах нь УБ., 2001

<sup>3</sup> Этика // Энциклопедический словарь. М., 2001. стр 358.

<sup>4</sup> Т.Сэнгэдорж. Хуульчийн мэргэжил. УБ., 1995. 59-р тал.

хишигтэн, туршуул, заргач, буурч, агтчин, хоньчин, тэрэгчин зэргийн ажил үүрэг гүйцэтгэгчдийг томилсон байна. ...Ийнхүү тэр үеэс шүүх, хууль цааз, цэргийн тагнуул туршуулын албаны эх үүсвэрийг тавьжээ<sup>1</sup>. Бид монголын оюуны соёл хөгжин боловсорч байсан түүхэн онцлог үе болох XIII зуунд ажил мэргэжлийн ёс зүйн шалгуур, үнэлэмж ямар түвшинд байсныг тодорхойлох зорилго тавилаа. Энэ нь монголчуудын ёс зүйн үзэл, сэтгэлгээг цогц байдлаар түүхчлэн авч үзэхэд дөхөм болох юм.

“Монголын нууц товчоо”-ны 124-р зүйлд “Чингис хаан Үнгур, Хадаан, Далдуурхан нарыг буурч болгоходо өглөөний зоогийг өнөд осолдохгүй, үдийн ундыг үүрд тасалдахгүй учир тогооч болгов” гэсэн ба Үнгур буурчид баруун, зүүн этгээдэд барих идээг түгээж, баруун талын хүмүүст зүй зүйгээр өгч идээ хүнсийг түгээвэл миний хоолой онгойж сэтгэл амардаг билээ хэмээн баяд түмнийг захируулахаар өгдөг тухай өгүүлжээ /213-р зүйл/. Мөн Бэлгүтэй, Хоролдой-Тахураун хоёрыг агтчин болгож,

Цуургатай тэрэгний  
Цуурга цүүг  
Цуцран эвдрэхгүй болгож  
Тэнхлэгтэй тэргийг  
Тэргүүр замд  
Тээглэн саатахгүй болгож  
Тэрэг гэрийн ажлыг

Тэгшлэн засаж явья гэсэн тул Хүчүгүрийг тэрэгчин /гэр тэрэгний засварчин буюу мужаан М.З/ болгохоор зарлигласан. /124-р зүйл/. Чингис хаан Найманы Таян хантай байлдахаар болоход “Миний морьд тарган байна. Агтыг туранхай гэж шалтгаацаж яаж болно” гэсэн нь агтчин хүн төрийн түшиг, улсын аюулгүй байдлыг хамгаалах их үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулдаг хариуцлагатай албатай байсныг гэрчилнэ /190-р зүйл/. Түүнчлэн Таян ханы аймгаас зугатсан уйгар газрын Тататунгаг өвөртөө байсан тамганы тухай үнэнч шударгаар мэдүүлсэн төдийгүй олон зүйл бичиг, хууль, цэргийн бодлогын утга мэддэг тул Хасар улсын багшаар өргөмжилсөн /196-р зүйл/. Чингис хаан Шихихутагийг бүх улсын хулгайг цээрлүүлж, худлыг мохоож, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллаж бай гэж бүх улсын дээд заргач /шүүхч/ болгов. Чингис хаан Шихихутагийг хоёронттоо “миний үзэх нүд, сонсох чих” нь түүний хамгийн шударга, үнэнч, шадар нөхөр нь байсныг илэрхийлнэ. Хожмын судлаачид Шихихутаг хэргийг шийтгэхдээ бүх хүн хуулийн өмнө адил тэгш хариуцлага хүлээх, хэрэгт нотлох баримтыг заавал ашиглах, хүн ардыг гэмт хэрэгт хилсээр үл шийтгэх, хэргийн үнэн мөнийг заавал тогтоох, буруу шүүсэн шүүгчийг шийтгэх зэрэг зарчмыг баримталж байсан нь монголын хуульчид эртнээс хүnlэг чанартай байсныг харуулна<sup>1</sup> гэсэн байdag.

Монголын нэгдсэн улсыг байгуулахад олон аян дайн хийсэн ба, тухайн үеийн цэргийн урлагийн гайхамшигийг нэрт монголч эрдэмтэн Л.Н.Гумилёв “Монголын эргэн тойрны улс хулчгар доройдоо ялагдаагүй.

<sup>1</sup> Монгол улсын түүх /Ред., Ж.Болдбаатар/ УБ., 1999 80-р тал

<sup>1</sup> С.Бадарч Шихихутаг төрийн анхны заргач /шүүхч/ “Цагдаа” сэтгүүл УБ., 1995 48 дахь

хамгийн гол нь тэдний цэргийн урлагт байсан юм"<sup>2</sup> гэж үнэлсэн байдаг. Чингис хаан Жорчидайг Хэрэйтэй байлдахад алхинчийн /хошууч<sup>3</sup>/ үүргийг амжилттай гүйцэтгэсэн:

“Алалдах өдөр  
Амиа хайрлахгүй  
Ачийг хүргэж  
Байлдах өдөр  
Байраа алдахгүй

Баатарлан зүтгэсэн"-ийг үнэлсэн байдаг /208-р зүйл/. Алхинч /туршуул/ нарын ажлын ёс суртахууны үүрэг хариуцлагыг ийнхүү тодорхойлжээ.

Чингис хаан ёс зүйгээ баримталдаг албатууд, шадар нөхөддөө эрх ямба, шан харамж, алдар хүндийг зарлигаар хайлрадаг байсныг дурьдахгүй өнгөрч болохгүй. Жишээ нь: хоньчин Дэгэйг мянганы ноён /222-р зүйл/, Бадай Хишилиг хоёр адуучинг хорчин болгож хуримд хундага дэвшүүлж, дархан эрхтэй жаргаж явахыг зарлиг болгосон байдаг /212-р зүйл/<sup>5</sup>. Манай улсад нийгмийн амьдралын олон бусармаг үйл явдал, авилгал, тал тохой татах зэрэг зөрчлүүд мэргэжилтэй боловсон хүчин буюу төрийн албан тушаалтан, албан хаагчдын шударга бус, үүрэг хариуцлагаа ухамсарлаагүй байдлаас үүсэх нь цөөнгүй байдаг. Жишээ нь, сүүлийн хоёр жилд зөвхөн албан тушаалын гэмт хэрэг 459 /зөвхөн илэрсэн нь/ үйлдэгдсэн байна<sup>6</sup>. Мэргэжлийн ёс зүй нэлээд доголдож байгаа өнөө үед түүний шалтгааныг тодруулах, боловсронгуй болгох арга замыг судлахад түүхэн туршлагаа эргэж харах хэрэгтэй юм.

XIII зууны үед Чингис хаан төрийн ажил, албанад тавигдах шаардлага, зарчмын хувьд: 1-рт, ёс суртахууны үнэлэмжээр буюу төрдөө үнэнч зүтгэх, эрэлхэг баатарлаг, шударга байх, хаан эзэндээ хүндэтгэлтэй хандах чанаруудыг хамгийн чухалд тооцдог нь тодорхой байна. 2-рт, ажил мэргэжлийн /албандаа/ ур чадвар, мэргэшсэн байдлыг харгалздаг байжээ. Эдгээр мэргэжлийн ёс зүйн шаардлага, зарчим, хэм хэмжээ, үнэлэмж зэрэг нь Монголын нэгдсэн төр улсыг төвхнүүлж, олон иргэн гар газар, хөл хөсөр тавин жаргахын нэгэн эш болсон гэх үндэстэй байна.

### *The Secret History of Mongols and professional ethics*

#### Summary

We considered the ethical demands principles and standards of the attitude of the mongols in the United impire of Mongolia, to works and proffessions how was it in the great "The secret history of Mongolia".

<sup>2</sup> Гумилёв.Л.Н Евразийн түүхээс УБ.,2000

<sup>3</sup> Д.Цэрэнсодном Монголын нууц товчооны орчуулга тайлбар УБ.,2000 35 дахь тал

<sup>4</sup> Монголын нууц товчоо. УБ.,1990. 180 дахь тал

<sup>5</sup> Мөн тэнд.

<sup>6</sup> Монгол улсын статистикийн эмхэтгэл. УБ.,2002.

**Ном зүй:**

1. Гумилёв.Л.Н., Евразийн түүхээс. УБ.,2000
2. Краткий тольковый словарь эдукологических понятий. УБ.,1994
3. Монголын нууц товчоо УБ. ,1990
4. "Этика" энциклопедический словарь. М.,2001